



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 59.1 дэх хэсэг, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 29.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын биелэлтэд хяналт тавьж, чанд сахиулах арга хэмжээ авч ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАГЧИЙН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИСТОЙ
ЯВУУЛАХ ЁС ЗҮЙН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын төлөөлөгч (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх)-ийн бизнесийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээг тогтоох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ёс зүйн зөрчил гэдэгт холбогдох хууль, тогтоомж Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр болон энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай, болгоомжгүй үйлдлийг ойлгоно.

1.4. Энэхүү журмыг даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээд /тэдгээрт ажиллагсад/ бизнесийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

**Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн баримтлах
зарчим, тэдгээрт тавигдах шаардлага**

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

- 1/ хууль, шударга ёсыг дээдлэх;
- 2/ ил тод байх;
- 3/ даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх;
- 4/ даатгуулагчид шуурхай үйлчлэх;
- 5/ шударга өрсөлдөөнийг эрхэмлэх;
- 6/ даатгагчийн эрх, ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах;
- 7/ даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

1/ ажил үйлчилгээ явуулахдаа хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандана;

2/ санхүүгийн тайландаа компанийн актив, пассив, орлого, зарлагыг бүрэн гүйцэд, бодитой тусгах бөгөөд аливаа тайлан, мэдээ, данс бүртгэл, баримт материалыг санаатайгаар будлиантуулах, буруу гаргах, устгах, тэдгээрийг нуун дарагдуулахгүйгээр зохих заавар, стандартын дагуу үнэн зөвөөр цаг тухайд нь төрийн эрх бүхий байгууллагад мэдээлэх, ирүүлэх, иргэдэд даатгагчаа чөлөөтэй сонгох боломж, бололцоогоор хангана;

3/ даатгалын хураамжийн хэмжээг үндэслэлгүйгээр бууруулахаас зайлсхийх бөгөөд даатгалын хураамжийн хувь хэмжээг актуарын тооцоог үндэслэн даатгалын объектод эрсдэл тохиолдох магадлал, түүний шинж чанар, зах зээлийн үнэлгээ, хугацаа, хамрах хүрээ зэргийг харгалзан тогтооно;

4/ Хорооноос баталсан заавал болон сайн дурын даатгалын хэлбэр тус бүр дээр баримтлах хураамжийн хувь хэмжээнээс бууруулахгүй байна;

5/ даатгалын гэрээний стандарт, нөхцөлийг боловсруулахдаа талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлаж, Хороогоор хянуулсан байна;

6/ төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг болон компанийн дотооддоо мөрддөг дүрэм, журам зааврыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ үйлчилгээний болон харилцааны өндөр соёлтойгоор ажиллахыг эрхэмлэвэл зохино;

7/ шударга өрсөлдөөнийг эрхэмлэх бөгөөд өрсөлдөгчийн талаар нэр хүндийг нь гутаасан худал мэдээлэл, цуурхал тараасан сурталчилгаа явуулахгүй байж харилцан хүндэтгэлтэй хандана;

8/ даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний цар хүрээг тэлэх, түүний чанар, соёлын болон даатгалын зах зээлийн ач холбогдлын талаар ажилтнууд, даатгуулагч, олон нийтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, олон түмний итгэл, үнэмшлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчид хоорондоо санаачлагатайгаар мэдээлэл солилцож байхыг эрмэлзэнэ;

9/ Даатгалын тухай хуулийн 9.1-т заасны дагуу даатгагчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ;

10/ даатгалын хохирол үнэлэгч, даатгалын компани нь даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд хохирлын хэмжээг бодитой, үнэн зөв тогтоож, нөхөн олговрыг даатгуулагчид тогтоосон хэмжээнээс бууруулахгүйгээр бүрэн, шуурхай олгоно.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан дараах шаардлагыг хангаж ажиллана.
Үүнд:

1/ эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, шаардлага, мэдэгдлийг зөрчсөн, зөрчихийг санаархсан удирдлагаас өгсөн үүрэг, даалгаварын сөрөг талыг удирдлагадаа хэлж анхааруулах;

2/ даатгагч, даатгалын хохирол үнэлэгчийн ажилтан ойр дотны харилцаатай болон сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй иргэн, хуулийн этгээдийн даатгалын нөхөн төлбөрийг хариуцан гүйцэтгэх, хохирлыг үнэлэхээс сайн дураараа татгалзах;

3/ өөрийн эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадвар, дадлага туршлага дутагдалтай гэж үзвэл даатгалын үйлчилгээнээс сайн дураараа татгалзах;

4/ шинээр мэргэжлийн болон даатгалын салбарын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн акт, мэдээлэлтэй байнга танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

5/ даатгуулагчидтай даатгалын гэрээ байгуулахдаа тэдний эрх, үүргийн талаар байнга сануулах;

6/ энэ журмын 3.1.4-т заасны дагуу мэдээлэл тараасан бол өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан /төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, мэдээллийн албаны ажилтан/ олон нийтэд мэдээлж, нэн даруй залруулах.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид (цээрлэх) хориглох зүйл.

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн удирдлага, ажилтан дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

1/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө даатгуулагч, түүний төлөөлөгчөөс шан харамж авах, өгөх, шаардах зэргээр даатгалын салбарын нэр хүндийг унагаах, харшлах үйлдэл хийх;

2/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх ашигт үл нийцэх үйл ажиллагаанд нэр төр, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан хувь хүн, хуулийн этгээдэд аливаа давуу тал олгох, хөнгөлөлт үзүүлэх, өөрийн боломжийг хэтрүүлэн ашиглах, хуурамч бичиг баримт үйлдэх;

3/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь өөрийн компани, түүний удирдлага болон төрийн эрх бүхий байгууллага, үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйлдэл гаргах;

4/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол, зар сурталчилгаа болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь олон нийтийг төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан мэдээлэл байх;

5/ даатгалын хохирол үнэлэгч нь даатгалын компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн нягтлан бодогч, мэргэжилтэн зэрэг албан тушаалтан байх;

6/ даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгч нь даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхлэх;

7/ ажил төрлийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах замаар удирдлагаас шийдвэр гаргахад саад учруулж, цаг алдагдуулах;

8/ Хорооноос явуулж буй шийдвэр, бодлогын арга хэмжээнүүдийг олон нийтэд гуйвуулан хүргэж шүүмжлэх;

9/ даатгуулагчидтай харилцахдаа хүнд суртал гаргах, аашилж зандрах, айлган сүрдүүлэх, дарамтлах, тэдгээрийн мэдлэг, мэдээллийн дутмал байдлыг ашиглан хууран мэхлэх, нөхөн төлбөр үндэслэлгүйгээр олгохоос зайлсхийх зэргээр бусармаг үйлдэл гаргах;

10/ хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах;

11/ компанийн болон даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг Даатгалын тухай хуулийн 81.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 43.2 дахь хэсэг болон бусад хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхолын үүднээс ашиглах, задруулах.

Дөрөв. Хариуцлага

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний ажиллагсад нь хууль тогтоомж, Хорооны шийдвэр, энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн бол түүний ёс зүйн зөрчлийн шинж байдал, хор уршиг, нийгэмд учруулсан хохирлын хэмжээ, анх буюу давтан үйлдсэн зэргийг харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хороо дараах шийтгэлийн аль нэгийг нь ногдуулна. Үүнд:

1/ сануулж, хамт олонд мэдээлэх;

2/ олон нийтэд зарлах;

3/шагналын тодорхойлолтоос хасах, сургалт, семинарт оролцох эрхийг хязгаарлах;

4/ эрх бүхий албан тушаалтныг ажлаас халахыг шаардах;

5/тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийхийг үүрэг болгох;

6/Даатгалын тухай хуулийн 68.1 дэх хэсэг болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу албадлагын арга хэмжээг хэрэглэх.

4.2. Ёс зүйн нэг зөрчилд шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй.

4.3. Хууль, тогтоомж, энэ журмыг зөрчсөн ажилтанд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан шаардуулалгүйгээр тухай бүр сахилгын шийтгэлийг ногдуулж байна.

4.4. Иргэн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг Хорооны Даатгалын газарт бичгээр ирүүлэх ба боломжтой бол нотлох баримтыг хавсаргах, түүнийг хүлээн авсан Хорооны ажилтан мэдээлэгчийн нэрийг нууцална.

4.5. Зөрчил гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний ажилтны талаарх мэдээллийг Хорооны Даатгалын газрын мэдээллийн санд хадгална.

--ooOoo--